

*В.Пүрэвбаасан-ХСИС, Хууль сахиулах удирдлагын
академийн Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн дэд профессор. хурандаа*

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛНЬ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БОЛОХ НЬ

Түлхүүр үг: Аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал

Товч агуулга: Аюулгүй байдал, цэргийн албаны аюулгүй байдал, цэргийн албаны аюулгүй байдлын онол, арга зүйн ойлголтуудыг тусгасан.

Оршил:

“Аюулгүй байдал” гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарлаж байна. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг.

Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг Я.Цэвэлийн тайлбар тольд: “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй” , В.Далийн тайлбар тольд: "аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх"*² гэж тайлбарлажээ.

Аюулгүй байдлыг сахих үйл ажиллагаа нь нийгэмд зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, хамгаалалтын болон онцгой байдлын албаны зэрэг хүчний байгууллагын бүтцийг буй болгон, улмаар бүхэлдээ дэлхий ертөнцийн нийт хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй НҮБ-ыг байгуулахад хүргэсэн байна.

Аюулгүй байдлын тогтолцоо “хэврэг” сул байх нь улс орон задрах, үндэстэн ястан устах, цус урсгасан зөрчил мөргөлдөөн үүсэх, материаллаг үнэт зүйлс эвдрэн сүйдэх зэрэг гай гамшигт хүргэдэг байна.

Сүүлийн үед аюулгүй байдал нь байгаль, нийгэм, техникийн салбар бүрийн онцлогт тохирсон аюулгүй байдлыг хангах тогтолцоо болон бие даасан шинжлэх ухаан болтлоо хөгжиж, аюул, занал, заналхийлэл, эрсдэл гэсэн үндсэн ухагдахуунуудыг бий болгож байна. Өнөө үеийн улс, үндэстэн бүхэнд даяаршлын аюулгүй байдал, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдал.

Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966.60 дахь тал

² Даль В.И. Толковый словарь русского языка. 2001 .с.44

үндэстний аюулгүй байдал гэсэн 3 төвшинд аюулгүй байдлын асуудал түгээмэл яригдаж байна.

Аюулгүй байдлын ерөнхий онолыг бүрдүүлэгч шинжлэх ухаан нь гүн ухаан, нийгэм судлал, улс төр судлал, эдийн засгийн шинжлэх ухаан, мөргөлдөөн судлал, сэтгэл зүй, хууль зүйн шинжлэх ухаан, системийн судлал юм.

Аюулгүй байдлын тусгай онолын үүрэг бүхий шинжлэх ухаан нь анагаах ухаан, чичирхийлэл судлал, цацраг судлал, хөдөлмөрийн аюулгүй байдлын онол, найдвартай байдлын онол, эрсдэлтийн онол, аюул сүйрлийн онол, цэргийн шинжлэх ухаан. түүний дотор цэргийн албаны аюулгүй байдал багтаж байна.

Үүний хамт ийм онол нь дотоод, гадаад улс төрийн харилцааг зохицуулж байгаа өөрийн улсын болон олон улсын эрх зүйн баримт бичгүүд, ялангуяа хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын зарчимд тулгуурлах нь зүйтэй.

Үндсэн хэсэг:

1. Мэдээллийн аюулгүй байдал МУ-ын ҮАБ-ын

бүрэлдэхүүн хэсэг болох нь

Аливаа аюулгүй байдлыг хангахын тулд аюулгүй байдлын үзэл баримтлал, шинжлэх ухааны үндэслэл, дүрэм, заавар боловсруулах нь чухал. Энэ нь тухайн аюулгүй байдлыг хангах талаар гаргах бусад эрх зүйн актуудын үндэс, үйл ажиллагааны удирдлага болдог.

Байгууллагын үйл ажиллагааны төрөл, чиглэлээс үл хамааран байгууллага бүрийн оршин тогдох үндэс нь зорилго байдаг. Хувийн хэвшлийн байгууллага хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийн үнэ цэнийг дээшлүүлэхийг зорьдог бол төрийн байгууллага ард иргэд, олон нийтийн эрх ашгийг хамгаалах, сайжруулахад чиглэсэн үйлчилгээг зүй зохистой, үр дүнтэй үзүүлэхийг зорьдог.

Манай улсын хувьд дээрх зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэх аюулгүй байдлаа хамгаалах гол тулгуур нь “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” юм.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” гэж заасан.

Эндээс Аюулгүй байдлын тухай ойлголт нь гадаад дотоод таатай нөхцөл хангагдахыг хэлж болох юм. Мөн уг бодлогын баримт бичгийн гуравдугаар

зүйлд "үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам"-ыг тусгажээ. Үүнд:

ЗЛ.Оршин тогтнохуйн аюулгүй байдал / Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн./

3.2. Эдийн засгийн аюулгүй байдал / Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох. хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална./

3.3. Дотоод аюулгүй байдал / Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн./

3.4. Хүний аюулгүй байдал / Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн./

3.5. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал / Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн./

3.6. Мэдээллийн аюулгүй байдал / Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн./¹ гэж тус тус заажээ.

Аюулгүй байдал судлалын үндсэн үүрэг нь:

- Аюулгүй байдлын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг нээн илрүүлж, тэдгээрийн тухай

¹ “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”.УБ.,2010,3 дугаар зүйл.

системчилсэн мэдлэгийг бий болгон, үүнийхээ үндсэн дээр аюулгүй байдлын ерөнхий онолыг бүтээх' билээ.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн

3.4. Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

3.4.1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;

3.4.2. нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;

3.4.3. иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;

3.4.4. эдийн засгийн аюулгүй байдал;

3.4.5. шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;

3.4.6. мэдээллийн аюулгүй байдал;

3.4.7. монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;

3.4.8. хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;

3.4.9. ЭКОЛОГИЙН аюулгүй байдал.

3.4.10. хүнсний аюулгүй байдал.

4.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дараахь үндсэн зарчмыг баримтална:

4.1.1. улс, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх;

4.1.2. хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;

4.1.3. хууль дээдлэх;

4.1.4. НЭГДМЭЛ, харилцан уялдуулан зохицуулагдсан байх;

4.1.5. шуурхай, тасралтгүй байх;

4.1.6. бодит мэдээлэлд үндэслэх;

4.1.7. төрийн байгууллага, иргэд харилцан хариуцлага хүлээх;

4.1.8. үндэсний эв нэгдлийг эрхэмлэх;

4.1.9. нээлттэй байх.

7.2.Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй^{1 2} хэмээн тус тус хуульчилжээ.

Дэлхийн олон улс оронд өөрийн улсын аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн, арга замыг гадаад аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал гэсэн үндсэн хоёр бүрэлдэхүүнд хуваан гадаад аюулгүй байдлаа Зэвсэгт хүчин, батлан хамгаалах, гадаад харилцааны бодлогодоо тусган, дипломат харилцаагаар харин дотоод аюулгүй байдлаа улс орон доторх засаглалын бүтэц, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын хүчээр хангаж байна.

¹ Б.Эрдэнэчимэг."Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого",УБ.,2016,т.29.

² "Үндэсний аюулгүй байдлын тухай".УБ.,2001.

Дээрх эрх зүйн баримт бичгүүдэд дүгнэлт хийхэд мэдээлийн аюулгүй байдал нь МУ-ын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагаа, хэрэгжүүлэх үүрэг болох нь харагдаж байна.

2. Мэдээллийн аюулгүй байдлын тухай ойлголт

Дээрхээс уялдуулан мэдээллийн технологи асар хурдацтай хөгжин, дэлхийн хаана ч хэрэгтэй мэдээллээ хамгийн хурдан авах боломж бүрдэж, энэ нь байгаа тул төрийн алба хаагч гэлтгүй хүн бүр мэдээллийн аюулгүй байдлын тухай ойлголттой болох нь зайлшгүй шаардагдаж байна.

Мэдээллийн аюулгүй байдал (МАБ) гэдэг нь өргөн утгаараа “Нийгэм, институт, байгууллагын мэдээллийн орчны хамгаалагдсан байдал”, эсвэл Мэдээлэл, өгөгдөл, түүнийг дэмжих дэд бүтцийн хамгаалагдсан байдал (байгууллагын аюулгүй байдалтай ижил болж байна). Гэхдээ эдгээр ойлголт зарим талаар явцуу шинж чанартай.

Дээрхээс гадна дэлхий дээр дараах олон янзын тодорхойлолт байдаг: "Мэдээллийн нууцлагдсан, бүрэн бүтэн болон хүртээмжтэй байдлыг хангасан байдал". Тодруулга: Үүнээс гадна үнэн бодит байдал, тайлагнах байдал, үл татгалзах байдал, найдвартай байдал гэсэн шинж чанар байна. (ISO/IEC 27000:2009)

"Нууцлагдсан, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг хангах үүднээс Мэдээлэл, мэдээллийн системд зүй бус, зөвшөөрөлгүй хандах, ашиглах, нээлттэй болгох, эвдлэх, өөрчлөх, устгах үйлдлээс хамгаалсан байдал." (CNSS, 2010)

"Зөвхөн эрх олгодсон хэрэглэгч (нууцлагдсан байдал) үнэн зөв бүрэн мэдээлэлд (бүрэн бүтэн байдал) шаардлагатай үедээ хандах (хүртээмжтэй байдал) боломжийг баталгаажуулсан байх." (ISACA, 2008)

"Мэдээллийн эрсдэл болон хяналтууд тэнцвэртэй байгаа гэдгийг сайн мэдэж байгаа мэдрэмж." (Anderson, J., 2003)

"МАБ гэдэг нь мэдээллийг хамгаалж зүй бус талуудад мэдээлэл задрах эрсдлийг багасгахыг хэлнэ.

" (Venter and Eloff, 2003) "Ямар ч хэлбэрийн мэдээллийг хаана байгаагаас нь (байгууллагын дотор, эсхүл гадна) үл хамааран мэдээлэл үүсгэж, боловсруулж, хадгалж, дамжуулж, устгаж байгаа системийн хүрээнд хүртээмжтэй бүх төрлийн механизм (зохион байгуулалт, техник, хүнээс хамааралтай болон хууль зүйн) ашиглан аюулгүй байдлын тогтолцоо хэрэгжүүлэх судалгаа, мэргэжлийн олон талт үйл ажиллагаа.

Аюул - МАБ-ыг ямар нэг байдлаар зөрчиж болох боломжуудыг хэлнэ. Аюул заналхийллийг хэрэгжүүлэх оролдлогыг халдлага, довтолгоон гэнэ. Ийм оролдлого хийж буй этгээдийг гэмт санаатан буюу халдагч гэнэ. Тэд аюул заналхийллийн эх сурвалж болдог. Аюул заналхийлэл нь МАБ-ын удирдлага, зохион байгуулалт, Мэдээллийн Систем, сүлжээн дахь эмзэг байдал, цоорхойг ашиглан хэрэгждэг. Цоорхойг хаах, арилгах хүртэл түүнийг ашиглах боломж оршоор байна. Үүний аюул заналхийллийн цонх гэдэг.

Цонх байгаа тохиолдолд амжилттай довтолгоон хийх боломж оршоор байна. Шинэ цоорхой, эмзэг байдал, түүнийг ашиглах хэрэгсэл, арга байнга шинээр үүсэж, бий болж байдаг тул аюул заналын цонх байнга оршин байдаг, тиймээс эдгээр цонхыг байнга хянан шалгаж, шуурхай бөглөж байх ёстой.

Орчин үеийн мэдээлэл, өгөгдөл, түүнийг дэмжих дэд бүтэц маш олон төрлийн аюултай нүүр тулж байна. Өргөн утгаар нь орчны, жам ёсны болон байгалын гаралтай аюул, техникийн болон хүнээс хамааралтай аюул гэж ангилж болно. Хүнээс хамааралтай аюулыг санаатай, санамсар болгоомжгүй гэж ангилна.

Мөн дараах шалгуураар ангилж болно: МАБ-ын үндсэн бүрдэл хэсгүүдээр нь: (хүртээмжтэй байдал, бүрэн бүтэн, халдашгүй байдал, нууцлалд заналхийлж буй аюул); Мэдээллийн системийн бүрдэл хэсгүүдээр нь: (өгөгдөл, ПХ, тоног төхөөрөмж, сүлжээ, дэмжигч дэд бүтцэд заналхийлж буй аюул); Хэрэгжүүлэх аргаар нь: (тохиолдлын/ санаатай үйлдэл, жам ёсны болон техногенный шинжтэй аюул); Аюул заналхийллийн эх сурвалж байгаа газраар нь (МС-ийн дотор/гадна байгаа аюул). Нийгмийн салбараар нь (Улс төрийн тогтолцооны эсрэг, Батлан хамгаалах чадварын эсрэг, нийгмийн сэтгэл зүйг удирдах чиглүүлэх зорилготой, нийгмийн онц чухал дэд бүтцийн эсрэг аюулууд гэх мэт)

Мэдээллийн Аюулгүй Байдлын мөн чанар буюу онцлог шинжүүд буюу өөрөөр хэлбэл англиар CIA гурвалжин гэгддэг

1. Нууцлагдсан байдал - Confidentiality,
2. Бүрэн бүтэн байдал - Integrity болон
3. Хүртээмжтэй байдал - Availability (НБХ - CIA) нь суурь ойлголт юм.

Мэдээлэл, мэдээллийг дэмжих дэд бүтэц, орчны нууцлагдсан, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг хангаж чадсанаар МАБ-ыг хангана.

Хүртээмжтэй байдал - Availability: Хүртээмжтэй байдал буюу мэдээллийн нөөц, үйлчилгээг хүссэн үедээ, дурын цэгээс ашиглах боломж

Бүрэн бүтэн байдал - Integrity: Бүрэн бүтэн байдал буюу мэдээлэл цаг үедээ нийцсэн, зөрчилдөөнгүй, хууль бусаар, зөвшөөрөлгүй өөрчлөх, нөлөөлөхөөс хамгаалагдсан байх

Нууцлагдсан байдал. нууцлал - Confidentiality: Нууцлагдсан, хамгаалагдсан байдал буюу үйлчилгээ, бүрдэл хэсгүүд болон дэд бүтцийн элементүүд хууль бус нэвтрэлтээс хамгаалагдсан байх, зөвхөн эрх бүхий этгээд хандах боломжийг хангасан байх.

Үүнээс гадна Үнэн бодит байх - Authenticity, Татгалзах боломжгүй байдал (Үл татгалзах шинж) - Non-repudiation -ийг хангасан байх нь МАБ-ыг хангах үндсэн шалгуурууд болдог.

Үнэн бодит байх - Authenticity: Мэдээллийн технологид өгөгдөл, хэлцэл, холболт, баримт бичгүүд жинхэнэ бөгөөд үнэн бодитой байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангаж чадахгүй бол хэрэглэгч болон талуудыг баталгаажуулах, зүй бус, гэмт үйлдлийг нотлох, тодорхойлох боломжгүй болдог. Тиймээс МАБ-ыг хангахад дээрх шинжийг хангасан байх нь чухал үүрэгтэй.

Татгалзах боломжгүй байдал (Үл татгалзах шинж) - Non-repudiation: Хууль зүйн ухаанд гэрээгээр хүлээсэн үүргээ чандлан биелүүлэх, үүрэг болон хэлцлээсээ татгалзах ёсгүй гэдэг ойлголтыг энэ нэр томъёо илэрхийлдэг.

Мэдээллийн технологид хэрэглэгч, үйлчлүүлэгч болон цахим хэлцлийн талууд хийсэн үйл ажиллагаа, үйлдлээсээ үл татгалзах шинжийг заавал хангасан байж аюулгүй байдал хангагддаг. Эдгээр нэмэлт шалгууруудыг хангахын тулд тоон гарын үсэг, нийтийн түлхүүрийн шифрлэлтийг өргөн ашиглаж байна. НБХ - CIA гурвалжинг цаашид өргөжүүлэх талаар багагүй маргаан өрнөдөг: Тухайлбал 2002 онд Donn Parker мэдээллийн 6 цөм бүрдэл хэсэг гэсэн саналыг гаргасан. (six atomic elements of information). Энэ бүрдэл хэсгүүд нь нууцлагдсан байдал -confidentiality, эзэмших байдал -possession, бүрэн бүтэн байдал - integrity, үнэн бодит байдал - authenticity, хүртээмжтэй байдал - availability болон ашиг тустай байдал - utility юм. Энэ талаар одоо болтол мэргэжилтнүүдийн дунд маргаан тасрахгүй байна.

Дүгнэлт:

Бүх аюулгүй байдал нь хоорондоо нягт холбоо уялдаатай бөгөөд эцсийн эцэст үндэсний аюулгүй байдал, түүний цөм болсон хүний аюулгүй байдлыг хангахад ерөнхийдөө чиглэгддэг болох нь дээрх эрх зүйн актуудаас харагдаж байна.

Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

Мэдээллийн аюулгүй байдал гэж төрөөс улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр гаргах Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, ард иргэд

хангагдсан Монгол Улсын талаар гадаадад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ.

Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, гаднаас болон дотоодоос учирч болох халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэх, хор хохирол эрсдэл учирсан гэж үзвэл урьдчилан бэлтгэсэн заавар, журмын дагуу нэн даруй засаж, сэргээх, хариу арга хэмжээ авахад оршино.

Мөн аливаа аюулгүй байдлын асуудал нь өөрөө гадаад, дотоод аюулгүй байдал хангагдах таатай нөхцөл бөгөөд тэдгээр гадаад дотоод аюулгүй байдлын асуудлыг тэнцвэртэй эерэгээр оршиход тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлүүдийг шинжлэн тодорхойлж, хүчин зүйлүүдийн эерэг ба сөрөг үзэгдэл, бодит орчны тэнцвэртэй байдлыг хангуулах үйл ажиллагааг зохион байгуулах нь аюулгүй байдлыг хангах үндсэн арга юм гэж дээрх онолын болон эрх зүйн ойлголтуудаас дүгнэж байна.

Санал:

МУ-ын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын дотоод мэдээллийн аюулгүй байдал тодорхой хэмжээнд хангагдсан гэж үзэж болох хэдий ч цагийн байдлын хүндрэлтэй нөхцөлд эдгээр байгууллага хоорондын хамтын ажиллагааны мэдээ, мэдээллийг шуурхай бодитой дамжуулах асуудлыг судлаж, мэдээллийн аюулгүй байдлын нэгдсэн ойлголттой болох нь зүйтэй гэж үзэж байна.